

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН
ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ /2019-2021 он/

АУДИТЫН КОД: АГГ-2022/22-ШТА-ГА

Улиастай сум 2022 он



Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа
Утас: 7046-3612, Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn
Аудитын менежер Б.Дагвасүрэн
Утас: 7046-3783, Цахим хаяг: dagvasurenb@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Жалбаа
Утас: 89330330, Цахим хаяг: jalbaab@audit.gov.mn
Аудитор Г.Баасанжаргал
Утас: 990032514, Цахим хаяг: baasanjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу:
Цахим хуудас www.audit.mn

АГУУЛГА

.....	0
Товчилсон үгийн тайлбар.....	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, шалгуур үзүүлэлт, стандарт, арга зүйн талаарх мэдээлэл	2
Ерөнхий мэдээлэл	4
БҮЛЭГ 1. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨРИЙН БОДЛОГО ТӨҮГ-Т ҮР ДҮНГҮЙ БАЙНА.....	4
1.1 Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн засаглалыг хөгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдээгүй байна.....	4
1.2 Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төрийн болон орон нутгийн өмчийн засаглалыг сайжруулах зорилт орон нутагт хангалтгүй байна.	5
БҮЛЭГ 2. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮР АШИГТАЙ БАЙНА УУ	5
2.1 Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтод түвшнийг үндэслэлтэй төлөвлөж, хянаж, батлаагүй байна. .	5
2.2 Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орлого бүрдүүлэлт зорилтод түвшиндээ хүрээгүй байна.	6
2.2.1 Төлөвлөсөн орлогоо бүрэн төвлөрүүлээгүй байна.Error! Bookmark not defined.	
2.2.2 Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар, төлбөр хураамжийг бүрэн төвлөрүүлсэн байна. Error! Bookmark not defined.	
2.3 Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа зорилтод түвшнийг хангаж үр ашигтай ажиллах үндэс уг байгууллагад байхгүй байна.	7
2.4 Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаа зардал үр ашигтай хэмнэлттэй байдлыг хангаж байна.	7
БҮЛЭГ 3. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨТЭЙ БАЙНА.....	8
3.1 Хөндлөнгийн хяналт үр нөлөөтэй байна.....	8
3.2 Дотоод хяналтын тогтолцоо оновчтой, хяналт үр нөлөөтэй байна уу	9
3.3 Мэдээллийн иж бүрэн, үнэн зөв, ил тод байдлыг хангаж байна.	10
ДҮГНЭЛТ	10
ЗӨВЛӨМЖ	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
ИНҮТ	Иргэний нисэхийн үндэсний төв
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ТХА	Техник хангалтын алба
ТТГ	Тоног төхөөрөмжийн газардуулга
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
НААХЗА	Нислэгийн аюулгүй ажиллагаа хяналт зохицуулалтын алба
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

Аудитын зорилт, хамарсан хүрээ, шалгуур үзүүлэлт, стандарт, арга зүйн талаарх мэдээлэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, МУЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “төрийн аудитын байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний дагуу аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтын үр нөлөөг үнэлж дүгнэн, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтыг хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- ✓ Компанийн засаглалын бодлого үр дүнтэй эсэх
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа үр ашигтай эсэх

Аудитын хамарсан хүрээ	✓ Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хяналт үр нөлөөтэй эсэх Аудитад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Компанийн тухай хууль, УИХ, ЗГ-аас гаргасан тогтоол, тухайн хуулийн этгээдийн ТУЗ-өөс гаргасан шийдвэр, бусад хууль эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, гүйцэтгэх удирдлага, холбогдох төрийн захиргааны төв болон мэргэжлийн байгууллага, тэдгээрийн ажлын албадын 2019-2021 оны үйл ажиллагааг хамрууллаа. Тосонцэнгэл сумын нисэх буудал ТӨҮГ-ын үйл ажиллагаанд аудитыг гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын үндсэн ойлголтын удирдамж УДИР 3910, УДИР 3910, УДИР 3920, МУ-ын төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, МУЕА-ын баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглаж гүйцэтгэлээ. Аудитаар хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтод түвшний төлөвлөлт, хяналт, санхүүгийн үйл ажиллагаа, үр ашигт судалгаа хийх, нэгтгэсэн дүн шинжилгээ, харьцуулалт хийх, мэдээллийн ил тод нээлттэй байдал, хяналтын тогтолцооны үр нөлөө зэрэг үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт тайлагналыг холбогдох баримт материалыг үндэслэн тулган баталгаажуулах, үнэлгээ хийх, асуудал хариуцсан албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах зэрэг аудитын горимыг хэрэгжүүлж ажиллаа. Аудитын асуудлын шинжилгээ, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт гарган зөвлөмж боловсрууллаа. Аудиттай холбоотой дараах хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглав. Үүнд: Төсвийн тухай хууль, Иргэний нисэхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, компаний тухай хууль, Иргэний нисэхийн дүрмүүдийн шаардлага болон

**Аудитын багийн
бүрэлдэхүүн, хугацаа**

батлагдсан Хязгаарлагдмал Аэродромын ерөнхий заавар, журам, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, ИНЕГ-ын хөдөлмөрийн дотоод журам, иргэний нисэхийн аюулгүй байдлын журам, мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам

Аудитыг дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа хянан удирдаж, аудитын менежер Б.Дагвасүрэн, ахлах аудитор Б.Жалбаа нар үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Г.Баасанжаргал аудитыг гүйцэтгэлээ.

ҮАГ-аас ирсэн төлөвлөгөөнд үндэслэн орон нутгийн онцлогт тохируулан аудитын дэд төлөвлөгөөг боловсруулах ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс ажлын 7 хоногийн хугацаанд гүйцэтгэж, аудитын төлөвлөгөөг 2022 оны 04 дүгээр сарын 25-ны дотор дарга тэргүүлэх аудитораар батлуулан, талбарын ажлыг 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор гүйцэтгэж, холбогдох газруудад хүргүүлж, ҮАГ-т нэгтгүүллээ.

Ерөнхий мэдээлэл

Тус нисэх буудал 1961 онд үүсэн байгуулагдсан. Тухайн үед Завхан аймгийн агаарын тээврийн газрын харьяанд ажиллаж байгаад 1993 онд ИНЕГ-ын харьяанд ажиллаж эхэлсэн. Одоогоор батлагдсан 16 орон тоотой. Гэрээт 2 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна. Энэ нисэх буудал нь баруун болон төвийн бүсийн аймгуудын нөөц (бэлтгэл) аэродром болдог. Өдөр бүр баруун аймгуудад нислэг үйлдэж буй агаарын хөлгүүдэд цаг агаарын болон холбоо навигацын үйлчилгээ үзүүлж бэлэн байдлыг ханган ажилладаг.

БҮЛЭГ 1. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨРИЙН БОДЛОГО УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ ХАМААРАЛГҮЙ БАЙНА.

1.1 Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн засаглалын бодлого улсын төсөвт үйлдвэрийн газрын үйл ажиллагаатай уялдаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 17.1-д Улсын төсөвт үйлдвэрийн газар нь эд хөрөнгийн талаар энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан төрийн байгууллага, албан газартай нэгэн адил эрхтэй байна гэсэн заалтын хүрээнд тухайн

байгууллага нь Зам тээврийн яам, ИНЕГ-т үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг нэгтгүүлдэг байна.

Тосонцэнгэл нисэх буудал нь төсвийн хөрөнгөөр санхүүжигддэг, төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг төрийн өмчит үйлдвэрийн газар бөгөөд тус байгууллага нь үйл ажиллагаандаа Иргэний нисэхийн тухай хууль, Иргэний нисэхийн дүрмүүдийн шаардлага болон батлагдсан Хязгаарлагдмал Аэродромын ерөнхий заавар, журмуудыг мөрдөн ажиллаж байна.

1.2 Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төрийн болон орон нутгийн өмчийн засаглалыг сайжруулах зорилтын хүрээнд хийгдсэн ажил хангалтгүй байна.

Тухайн байгууллагын 2019-2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан асуудалтай холбоотой арга хэмжээ тусгагдаагүй байна. Мөн дээд шатны төсөв захирагчаас хөтөлбөрт тусгагдсан асуудлаар хийсэн сургалт, өгсөн чиглэл байхгүй байна.


Тус байгууллагын өмчид эрх бүхий байгууллагууд нь НББ-ээр дамжуулан хяналтыг хэрэгжүүлдэг байна. УТҮГ-ын даргын тушаалаар хагас, бүтэн жилээр хөрөнгийн тооллого хийж, өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлтэд үндэслэн ИНЕГ-т хүргүүлэн холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэр гаргуулан акталж, данснаас хасан ажилладаг байна.

БҮЛЭГ 2. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮР АШИГТАЙ БАЙНА.

2.1 Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орлого, зардлын төлөвлөгөөг жишиг үнэтэй харьцуулан хянаж, баталжээ.

Тус байгууллага дараа оны орлого, зардлын төсвөө өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулан, албадаас санал авч тооцоолон хүргүүлдэг байна.

Хүснэгт 1. Төсөл, төлөвлөгөө харьцуулалт



Тосонцэнгэл нисэх буудал УТҮГ нь төсвийн төслөө бодит тооцоо судалгаанд үндэслэн тооцоолж хүргүүлдэг ч Зам, тээврийн хөгжлийн яам жишиг үнийн саналд үндэслэн хянадаг байна. Ингэхдээ УТҮГ-ын боловсруулан хүргүүлсэн төслөөс жил бүр дунджаар 53.4 сая төгрөгөөр бууруулан баталжээ.

2.2 Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орлого бүрдүүлэлт хангалтгүй байна.

Тосонцэнгэл нисэх буудал УТҮГ нь улсын төсвийн санхүүжилтийн орлого, буулт хөөрөлтийн орлого, бусад орлого гэсэн орлогыг бүрдүүлсэн байна.

Орлогын гүйцэтгэл		/сая.төг/					
д/д	Орлогын нэр төрөл	2019		2020		2021	
		Баталсан /тодотгол/	гүйцэтгэл	Баталсан /тодотгол/	гүйцэтгэл	Баталсан /тодотгол/	гүйцэтгэл
1	Улсын төсвийн санхүүжилт	431.3	425.5	549.8	527.9	540.8	455.1
2	Буулт хөөрөлтийн орлого	0.2	0.1	0.2	0.1	0.1	0
3	Бусад орлого	2.5	4.0	5.0	0.3	0.8	0.4
ДҮН		434.0	429.1	555.0	528.3	541.7	455.5

ИНЕГ-аас тухайн байгууллагын төсөвт тодотгол хийсэн хэдий ч гүйцэтгэлээр дутуу санхүүжүүлсэн байна. Энэ нь Сангийн яам тухайн байгууллагын төсвийн гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосонтой холбоотой байна.

УТҮГ-ын өөрийн үйл ажиллагааны хүрээнд төвлөрүүлэх орлогыг 2019 онд 0.8 сая төгрөгөөр давуулан биелүүлж, 2020, 2021 онуудад орлогын төлөвлөгөө биелээгүй байна. Сүүлийн жилүүдэд орлого тасарсан нь 2019 оноос зорчигч урсгал тасарсан, улсын нөөцөөс борлуулалт хийгдээгүй буюу тухайн нисэх буудалд онгоц буугаагүй зэрэгтэй холбоотой байна.

Цаашид үйл ажиллагааны орлогоо нэмэгдүүлэх зорилгоор үндсэн рейсийн нислэг хийхээр төлөвлөж байгаа хэдий ч тодорхой шийдвэрт хүрээгүй байна гэсэн тайлбар өгсөн.

Тус УТҮГ нь улс орон нутгийн төсөвт дараах нэр төрлийн татвар, төлбөр хураамжийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Татвар, төлбөр хураамжийн төвлөрүүлэлт

№	Татварын төрөл	Тайлан он		
		2019	2020	2021
1	Дундын суутгал/ суутган төлөгч	1.1	0.6	
2	Газрын төлбөр, агаарын төлбөр	4.2	4.3	4.0
3	Агаарын бохирдлын төлбөр	15.0	152.5	22.5
4	АТБӨЯХАТ, галт зэвсгийн АТ, ҮХХАТ	1.1	1.0	1.5
5	ХХОАТ	22.2	24.5	22.5
6	Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	1.4	1.9	
7	Нийгмийн даатгалын шимтгэл	72.2	77.8	76.8
Нийт		117.2	262.6	127.3

Дээрх татварын орлогуудыг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлж, холбогдох тайланг цаг хугацаандаа гаргаж хэвшсэн байна. Тус байгууллага нь татвар, НДШ-ийн өргүй ажилласан байна.

2.3 Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа зорилтод түвшнийг хангаж үр ашигтай ажилласан байна.

УТҮГ нь төсөвт байгууллагын статустай үйл ажиллагаа явуулдаг бөгөөд санхүүгийн үйл ажиллагаанд үр ашгийн тооцоо, шинжилгээг хийгээгүй байна.

Аудитаар тухайн байгууллагын үйл ажиллагаанд шинжилгээ хийж үзэхэд төсвийг жил бүр хэмнэсэн үзүүлэлттэй байна.

Харин зардал бүрээр нь судлан үзэхэд 2020 онд эд хогшил, урсгал засварын зардал 25.0 сая төгрөгөөр, томилолтын зардал 8.3 сая төгрөгөөр хэтрүүлсэн, бусад зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулжээ. Урсгал засварын зардал хэтэрсэн нь барилгын их засвар хийгдсэнтэй холбоотой байна.

Тус нисэх буудал нь үйл ажиллагаагаа хэвийн явуулах техник тоног төхөөрөмжийн нөөцөөр бүрэн хангагдсан байна. Тухайлбал: 50тн багтаамжтай 3 ширхэг агуулахтай бөгөөд ИНЕГ-ын нөөцийн 51,5 тн ТС-1 шатахуун хадгалагдаж байна. Уг агуулахад шатахууны нярав-лаборант 1, шатахууны сахиул 1 хүн тус тус бэлэн байдлыг ханган ажилладаг.

Мөн хөөрч буух шороон зурвасын хэмжээ 200х3000м, агаарын хөлөг хүлээн авах 70х35м цемент бетон талбайтай бөгөөд цагт 100 хүн хүлээн авах хүчин чадалтай, 3 давхар барилгатай байна. Үүнд нислэг хөдөлгөөн удирдах цамхаг, оффисын өрөө тасалгаа, сургалтын өрөө, холбоо навигацийн болон газрын үйлчилгээний ажилтнуудын өрөө, аюулгүй байдлын үзлэгийн цэг, ачаа тээш хүлээн авах олгох өрөө, зорчигчид зориулсан заал, зорчигч бүртгэлийн цэг, тусгай үзлэгийн цэг байрлаж аюулгүй байдлыг хангадаг. Төвийн болон баруун бүсийн нисэх буудлуудад шаардлагатай тохиолдолд мэргэжилтэй ажилтнууд нөхөн хангалтаар томилогдон ажилладаг байна.

Аудитад хамрагдаж буй онуудад тухайн байгууллагад их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчил бүхий гэрээ хийгдээгүй байна.

2.4 Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд санхүүгийн үйл ажиллагааны зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.

УТҮГ нь зардлын төлөвлөгөөг урсгал зардал хэлбэрээр нийт дүнгээр нь баталдаг байна. Батлагдсан зардлын цалин хөлс, бараа үйлчилгээний зардал, хөрөнгийн зардлын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.

Цалин хөлс: ИНЕГ-ын даргын тушаалаар тухайн байгууллагыг 16 орон тоотойгоор баталсан байна. Цалин хөлс, урамшууллыг холбогдох эрх бүхий байгууллагаас тогтоосон хэмжээ, хууль журмын дагуу тооцоолж олгосон байна.

Харин гэрээт ажилтны орон тоо батлагдаагүй байхад 2 хүн авч ажиллуулсан байна. Энэ нь уурын зуухын галлагаатай холбоотой зайлшгүй хэрэгцээтэй орон тоо байна.

Цалин хөлсний зардлын гүйцэтгэлийг судлан үзэхэд 2020, 2021 онуудад 69.7-13.4 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна. Энэ нь төсвийн хэмнэлтийн хүрээнд ИНЕГ-ын даргын тушаалаар 2020, 2021 онуудад илүү цагийн хөлс олгохгүй шийдвэр гаргасан, харьяалагдах салбаруудаас мэргэжлийн нөхөн хангалтын ажилчид авч ажиллуулаагүй, өндөр насны тэтгэвэрт гарсан ажилчдын оронд нөхөн томилгоо хийгээгүй зэрэгтэй холбоотой байна. Хангалтын алба хаагчдыг ИНЕГ-ын сургалтын төвөөс зохион байгуулсан сургалтад хамруулж ажиллах эрхийн үнэмлэхтэй болгосноор төсөв хэмнэх, ажлын үр ашиг дээшлэх нөхцөл бүрдсэн байна.

Бараа үйлчилгээний зардал: Аудитаар бараа үйлчилгээний зардлын зарцуулалтыг судлан үзэхэд үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан байдал ажиглагдаагүй бөгөөд зориулалт бус зарцуулсан дараах зөрчил байна.

- Ойгоос мод бэлтгэх зөвшөөрөлгүй иргэнээс худалдан авалт хийж түүний ойн нөөц ашигласны төлбөрт 1,930.2 мянган төгрөгийг төлсөн
- Шуудан холбооны зардлыг бэлнээр олгосон бөгөөд анхан шатны баримт хангалтгүй 180.0 мянган төгрөг
- Албан хаагчдад томилолтын хуудасгүй байхад томилолт олгосон 908.7 мянган төгрөг зэрэг байна.

Хөрөнгийн зардал: Тосонцэнгэл нисэх буудал нь хөрөнгө оруулалтын шинж чанартай дараах ажлуудыг хийсэн байна. Ингэхдээ хэмнэгдсэн зардлаас тухайн ажлуудыг санхүүжүүлжээ. Үүнд:

➤ 2020 онд барилгын их засварын 79,492.6 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг гүйцэтгэсэн бөгөөд 41,216.4 мянган төгрөгийг тус нисэх буудлаас, 32,231.1 мянган төгрөгийг иргэний нисэхийн ерөнхий газраас санхүүжүүлсэн байна.

➤ Шатахууны агуулахын ослоос хамгаалах тэгш талбайг цементлэхэд 16,920.8 мянган төгрөг, гадна камержуулахад 3,520.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн.

➤ 2021 онд халаалтын зуухыг шинэчлэлтийн ажилд 16,767.9 мянган төгрөг зэрэг байна.

Дээрх ажлуудыг ТБОНӨХБАҮХА-тухай хуульд заасан журмын дагуу худалдан авах ажиллагааг явуулсан бөгөөд худалдан авалт дууссаны дараах гэрээ, ажил хүлээлцсэн акт, гэрээ дүгнэсэн акт, тайлан болон гүйцэтгэлийг ИНҮТ-ын худалдан авах ажиллагааны тасаг болон санхүү эдийн засгийн төлөвлөлтийн газарт хүргүүлсэн байна.

БҮЛЭГ 3. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨТЭЙ БАЙНА.

3.1 Хөндлөнгийн хяналт үр нөлөөтэй байна.

Тосонцэнгэл нисэх буудал УТҮГ-ын үйл ажиллагаанд 2020 онд Тагнуулын ерөнхий газраас хяналт шалгалт хийсэн бөгөөд шалгалтаар харуул хамгаалалт, аюулгүй байдалд онцгой нөхцөл үүссэн үед ажиллах бэлэн байдлын төлөвлөгөө болон харуул хамгаалалтын журам байхгүй, ажлын бус цагаар гаднаас нэвтэрсэн иргэдийн бүртгэл хөтөлдөггүй, албаны өрөөнүүд лацгүй, хяналтын камер байдаггүй, онгоцны шатахууны агуулах үндсэн объектоос зайтай, сахиул нь харуул хамгаалалтын мэргэжлийн сургалтад хамрагдаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Шалгалтын үр дүнд гадна камержуулалт хийж, шатахууны сахиулыг харуул хамгаалалтын сургалтад хамруулж, ажлын бус цагаар нисэх буудалд нэвтэрч буй иргэдийн бүртгэлийг хийж хэвшсэн гэсэн тайлбар өгсөн.

Мөн “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр, гурван шатны хяналтыг зохион байгуулах” журмыг хэрэгжүүлдэг, шинээр орсон 3 ажилтан ИНЕГ-ын сургалтын төвд сургалтад хамрагдаж ажиллах эрхийн үнэмлэхээ авч шаардлага ханган ажиллаж байгаа зэрэг үр дүн гарсан байна.

ИНЕГ-ын хяналт, шинжилгээ дотоод аудитын албанаас санхүү болон үйл ажиллагаатай холбоотой хяналт шалгалтыг жил бүр хийсэн байна. Энэхүү шалгалтаар дараах зөрчлийг илрүүлсэн байна.

1. Урьдчилгаа цалин бодож олгохдоо цагийн бүртгэлийг үндэслэл болгоогүй, ажилласан хоногоос илүү болон дутуугаар тооцож олгосон
2. Шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлээгүй, алдаатай байршуулсан, иж бүрэн мэдээлээгүй
3. Ажлын байранд ажилласан ажилтны цагийн бүртгэлийг үндэслэн хүйтний нэмэгдлийг олгох ёстой байтал зайнаас ажилласан ажилтнуудад үндсэн цалингийн 10 хувиар тооцож хүйтний нэмэгдлийг олгосон.

4. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр, гурван шатны хяналтыг зохион байгуулах” журмыг хэрэгжүүлээгүй, дэвтэр хөтлөөгүй
5. Дотоод хяналт, шалгалт хийхдээ батлагдсан журам нь хэрхэн шалгалт хийх тухай аргачлал хангалтгүй, батлагдсан хяналтын хуудасгүй байдлаас шалгалтын агуулга бүрэн бус дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэхдээ батлагдсан удирдамж төлөвлөгөө батлуулаагүй
6. ИНЕГ-ын хөдөлмөрийн дотоод журмын 6.5.9-д “орон сууцны дэмжлэгт хамрагдсан ажилтныг байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй орон сууцанд амьдруулахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн
7. Сургалт зохион байгуулж ажилласан ч сургалтын үр дүнтэй байдал, ажилтнуудад мэдлэг олгосон нотолгоог бүрдүүлж шалгалт авах ажлыг орхигдуулсан зэрэг байна.

Тухайн байгууллага дээрх зөрчлүүдийг арилгаснаар нягтлан бодогчийн тухайд шилэн дансны мэдээллийг хугацаандаа, үнэн зөв мэдээлдэг болсон, цалинтай холбоотой зөрчил үүсгэхгүй, санхүүгийн программаа хүний нөөцтэйгөө хослуулан ажиллуулдаг болсон байна.

3.2 Дотоод хяналтын тогтолцоо оновчтой, хяналт үр нөлөөтэй байна.

Байгууллагын даргын 2019 оны 03 сарын 27-ны өдрийн А/06 тоот тушаалаар дотоод хяналт, шалгалтын нэгжийг 3 гишүүнтэй байгуулсан байна. Тус нэгж нь ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, гүйцэтгэлийг улирал бүр нисэх буудлын даргад танилцуулдаг байна.

Хяналт шалгалтыг гүйцэтгэхдээ мөрдөгдөж буй үйл ажиллагааны заавар, иргэний нисэхийн дүрмийн хүрээнд хяналт шалгалтын удирдамж, асуумжийг боловсруулж, чеклист хэлбэрээр хийсэн байна.

3.3 Мэдээллийн иж бүрэн, үнэн зөв, ил тод байдлыг хангасан байна.

Тосонцэнгэл сумын ЗДТГ, цагдаагийн хэлтэс, нэгдсэн эмнэлэг, онцгой байдлын хэлтэс зэрэг байгууллагуудтай нисэхийн аюулгүй байдлыг хангах талаар гэрээтэй ажиллаж, жил бүр сургалт сурталчилгаа хийдэг байна.

Мөн сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан “Агаарын хөлөг шувуу мал амьтантай мөргөлдөхөөс сэргийлэх салбар зөвлөл”-тэй хамтран ажилласнаар ийм төрлийн зөрчил дутагдал гараагүй байна.

Тухайн онуудад нийгмийн даатгалын тасагтай болон татварын хэлтэстэй хамтран, мэдээлэл солилцон ажиллаж ажилтнуудын нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, газрын болон галт зэвсгийн, автомашины татвар төлөлт хугацаандаа хийгдсэн байна.

Мөн Завхан аймгийн архивын тасгаас заавар зөвлөгөө авч баримтаа хүргүүлдэг ба устгах бичгийн түүвэр жагсаалтыг батлуулдаг байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах талаар нисэх буудлын даргын 2021 оны 06 сарын 15-ны өдрийн А/08 дугаартай тушаал гаргаж шилэн дансанд холбогдох мэдээллийг ИНЕГ-ын www.mcaa.gov.mn цахим хуудсанд байршуулдаг байна. Шилэн

дансны мэдээллийг хэрхэн оруулдаг талаар үзэхэд 2020 онд улсын төсвийн санхүүжилтийн орлого 158.5 сая төгрөгийг мэдээлээгүй байна.

Харин 2021 оноос дээрх зөрчлийг арилган шилэн дансны цахим мэдээллийг цаг хугацаандаа бүрэн оруулсан байна. Энэ нь ИНЕГ-ын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс зохиогддог онлайн сургалттай холбоотой байна.

ДҮГНЭЛТ

1. Төсвийг хянаж, батлахдаа жишиг үнийн саналд үндэслэж байна.
2. Улсын төсвийн санхүүжилт дутуу олгогдсон байна.
3. Татварын орлогуудыг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлж, өр, авлагагүй ажилласан байна.
4. Батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулсан байна.
5. Байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт үр нөлөөтэй байна.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА